



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Бялзуухай цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/55/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	9
4. Аудитын илрүүлэлт.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 31
танай -ны № -т

БЯЛЗУУХАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ М.АРИУНЖАРГАЛ
ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бялзуухай цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бялзуухай цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>33 935 171,76</u>	<u>34 096 506,18</u>
33	АВЛАГА	15,76	30 784,18
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	15,76	30 784,18
35	БАРАА МАТЕРИАЛ	33 935 156,00	34 065 722,00
351	Түүхий эд материал	31 802 356,00	32 527 422,00
35110	Тусгай зориулалттай материал	31 632 696,00	32 328 362,00
35130	Эм боох материал	169 660,00	199 060,00
354	Хангамжийн материал	2 132 800,00	1 538 300,00
35410	Бичиг хэргийн материал	143 000,00	143 000,00
35420	Аж ахуйн материал	1 073 300,00	801 300,00
35450	Барилгын засварын материал	594 000,00	594 000,00
35460	Хүнсний материал	322 500,00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1 609 062 290,83</u>	<u>1 595 921 369,51</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1 609 062 290,83	1 595 921 369,51
392	Биет хөрөнгө	1 303 542 290,75	1 290 501 369,39
39201	Барилга, байгууламж, орон сууц	1 319 938 685,42	1 351 638 685,42
39202	Хуримтлагдсан элэгдэл	(62 310 570,84)	(93 014 569,32)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	50 145 134,00	50 145 134,00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(32 531 618,40)	(36 855 984,28)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51 969 860,70	51 969 860,70
39208	Хуримтлагдсан элэгдэл	(32 048 449,13)	(37 296 435,53)
39214	Бусад үндсэн хөрөнгө	17 308 390,20	17 308 390,20
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8 929 141,20)	(13 393 711,80)
393	Биет бус хөрөнгө	305 520 000,08	305 420 000,12
39301	Програм хангамж	400 000,00	400 000,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(199 999,92)	(299 999,88)
39303	Бусад биет бус хөрөнгө	305 320 000,00	305 320 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1 642 997 462,59</u>	<u>1 630 017 875,69</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1 642 997 462,59</u>	<u>1 630 017 875,69</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1 642 997 462,59	1 630 017 875,69
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	305 320 000,00	305 320 000,00
512	Хуримтлагдсан үр дүн	457 910 198,77	444 930 611,87
51210	Өмнөх үеийн үр дүн	457 910 198,77	457 910 198,77
51220	Тайлант үеийн үр дүн	-	(12 979 586,90)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	879 767 263,82	879 767 263,82
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1 642 997 462,59</u>	<u>1 630 017 875,69</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	429 741 650,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	34 634 850,00
120	Нийтлэг татварын бус орлого	-	34 634 850,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	34 634 850,00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	34 634 850,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	395 106 800,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	354 764 200,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	354 764 200,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	390 000,00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	250 000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	140 000,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	39 952 600,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	39 952 600,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	442 721 236,90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	442 721 236,90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	429 566 919,90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	294 144 031,58
210101	Үндсэн цалин	-	193 891 538,58
210102	Нэмэгдэл	-	75 633 924,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	616 400,00
210104	Урамшуулал	-	24 002 169,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	39 600 400,00
210201	Тэтгэврийн даатгал	-	27 465 103,00
210202	Тэтгэмжийн даатгал	-	2 893 245,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	2 594 502,00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	604 323,00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	6 043 227,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	25 798 283,00
210301	Гэрэл, цахилгаан	-	3 326 235,00
210302	Түлш, халаалт	-	13 847 268,00
210303	Цэвэр, бохир ус	-	8 624 780,00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	4 926 084,00
210401	Бичиг хэрэг	-	53 645,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	201 900,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	204 000,00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	3 345 655,00
210408	Бараа материал акталсны зардал	-	1 120 884,00
2105	Нормативт зардал	-	17 111 800,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	16 000,00
210502	Хоол, хүнс	-	17 095 800,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1 142 100,00
210604	Урсгал засвар	-	1 142 100,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	500 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	500 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	46 344 221,32
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1 503 300,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	44 840 921,32
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	13 154 317,00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	13 154 317,00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	13 154 317,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	(12 979 586,90)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Дахин илэрхийлсэн үлдэгдэл	305 320 000.00	879 767 263.82	457 910 198.77	1 642 997 462.59
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайлант үеийн үр дүн			(12 979 586,90)	(12 979 586,90)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	305 320 000.00	879 767 263.82	444 930 611.87	1 630 017 875.69

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	-	396 567 694,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	396 567 694,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	354 764 200,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	354 764 200,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	390 000,00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	250 000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	140 000,00

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	39 952 600,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	39 952 600,00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	1 460 894,00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	1 460 894,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	=	396 567 694,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	396 567 694,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	381 952 483,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	294 174 800,00
210101	Үндсэн цалин	-	193 922 307,00
210102	Нэмэгдэл	-	75 633 924,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	616 400,00
210104	Урамшуулал	-	24 002 169,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	39 600 400,00
210201	Тэтгэврийн даатгал	-	27 683 856,00
210202	Тэтгэмжийн даатгал	-	2 979 136,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	2 383 309,00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	595 827,00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	5 958 272,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	25 798 283,00
210301	Гэрэл, цахилгаан	-	3 326 235,00
210302	Түлш, халаалт	-	13 847 268,00
210303	Цэвэр, бохир ус	-	8 624 780,00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	2 095 400,00
210401	Бичиг хэрэг	-	169 645,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	201 900,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	1 451 500,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	272 355,00
2105	Нормативт зардал	-	17 254 200,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	45 400,00
210502	Хоол, хүнс	-	16 773 300,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	435 500,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1 142 100,00
210604	Урсгал засвар	-	1 142 100,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	500 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	500 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1 387 300,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1 387 300,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	14 615 211,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1 460 894,00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	1 460 894,00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	13 154 317,00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	13 154 317,00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	394716800,00	381562483,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	394716800,00	381562483,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	394716800,00	381562483,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	294174800,00	294174800,00
210101	Үндсэн цалин	167857800,00	193922307,00
210102	Нэмэгдэл	99380500,00	75633924,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2535300,00	616400,00
210104	Урамшуулал	24401200,00	24002169,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39600400,00	39600400,00
210201	Тэтгэврийн даатгал	27780400,00	27683856,00
210202	Тэтгэмжийн даатгал	2955000,00	2979136,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2364000,00	2383309,00
210204	Ажилгүйдлийн даатгал	591000,00	595827,00
210205	Эрүүл мэндийн даатгал	5910000,00	5958272,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38810500,00	25798283,00
210301	Гэрэл, цахилгаан	9944800,00	3326235,00
210302	Түлш, халаалт	19977900,00	13847268,00
210303	Цэвэр, бохир ус	8887800,00	8624780,00
2104	Хангамж, бараа материалын зардал	1705400,00	1705400,00
210401	Бичиг хэрэг	78900,00	29645,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	63 900,00	201 900,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1 371 100,00	1 201 500,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	142 100,00	272 355,00
2105	Нормативт зардал	17 254 300,00	17 254 200,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45 400,00	45 400,00
210502	Хоол, хүнс	16 773 400,00	16 773 300,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	435 500,00	435 500,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1 142 100,00	1 142 100,00
210604	Урсгал засвар	1 142 100,00	1 142 100,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	561 400,00	500 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	561 400,00	500 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1 387 300,00	1 387 300,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1 387 300,00	1 387 300,00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	394 716 800,00	381 562 483,00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	354 764 200,00	354 622 100,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	354 764 200,00	354 622 100,00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	39 952 600,00	26 940 383,00
132001	Орон нутгийн төсвөөс	39 952 600,00	26 940 383,00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	390 000,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	390 000,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	390 000,00
2104	Хангамж, бараа материалын зардал	390 000,00
210401	Бичиг хэрэг	140 000,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250 000,00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	390 000,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	390 000,00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	250 000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	140 000,00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн Бялзуухай цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бейкер Тилли Далайван аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, эхний шатны хяналтыг ахлах аудитор, захирал Д.Мягмарсүрэн хэрэгжүүлж, 2 болон 3-р шатны хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, Орхон аймгийн төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн Бялзуухай цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн Бялзуухай цэцэрлэг нь Засаг даргын 2013 оны 09-р сарын 25-ны өдрийн А/496 дугаар захирамжаар байгуулагдаж, 2-5 насны хүүхдүүдэд СӨБ олгох үйл ажиллагаа явуулдаг ба дэлгэрэнгүй танилцуулбал:

- Багш бүр хүүхдийн эзэмшвэл зохих чадварын явц, үр дүнд тогтмол шинжилгээ хийж, сургалт үйл ажиллагааг бэлтгэлтэй үр дүнтэй зохион байгуулж, хүүхэд бүрийн онцлогт тохирсон сургалтын хөтөлбөрийн агуулгыг бүрэн эзэмшүүлэх,

- Багш ажлын байранд тасралтгүй хөгжих, бүтээлч арга зүйг хөгжүүлэх, сургалтын хөтөлбөрийг сонирхлын бүлэг, багаар хамтарч төлөвлөх, үр дүнг тооцох,
- Хүүхэд хамгаалалын бодлогын хэрэгжилтийг хангаж, хүүхдийг аливаа эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эцэг эхтэйгээ хамтран авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж, хүүхдийн аюулгүй орчинг хангах зэрэг үйл ажиллагааг явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн Бялзуухай цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 394,716.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,947.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,763.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн Бялзуухай цэцэрлэг нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,979.5 мянган төгрөгөөр буюу 0.8 хувиар буурсан байгаа нь бараа материалын үлдэгдэл 130.5 мянган төгрөг буюу 0.4 хувиар өссөн боловч үндсэн хөрөнгө 13,140.9 мянган төгрөг буюу 0.8 хувиар буурснаас хамаарч байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0.0	30.8	30.8
Бараа материал	33,935.2	34,065.7	130.5
Үндсэн хөрөнгө	1,609,062.3	1,595,921.4	(13,140.9)
Нийт хөрөнгө	1,642,997.5	1,630,017.9	(12,979.5)
Өр төлбөр	0.0	0.0	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,034,321.3	1,977,449.1	(56,872.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,034,321.3	1,977,449.1	(56,872.3)

Бараа материалын данс 34,065.7 мянган төгрөг болж өмнөх оноос 130.5 мянган төгрөгөөр тайлант үеийн бараа материалын орлого зарлагын дүнгээс хамаарч байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,595,921.4 мянган төгрөг болж өмнөх оноос 13,140.9 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын хэмжээнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,977,449.1 мянган төгрөг болж 56,872.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Орхон аймгийн Бялзуухай цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 927,258.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 927,258.0 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 258,120.6 мянган төгрөгөөр бууруулан 669,137.4 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төсвийг 2 удаа тодотгол хийж 258,120.6 мянган төгрөгөөр бууруулж, 669,137.4 мянган төгрөгөөр баталжээ. Хоолны зардлыг бууруулж тодотгол хийсэн байна. Мөн хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж, тэтгэвэрт гарах тэтгэмжийг төсвийн төслөөс хасаж төсвийг баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх СӨБ-ын арга хэмжээг хэрэгжүүлэхээр 354,764.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 39,952.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, нэмэлт санхүүжилтаар 390.0 мянган төгрөгөөр санхүүжиж, урсгал үйл ажиллагаанд 396,567.7 мянган төгрөгийг зарцуулж, 142.1 мянган төгрөгийг улсын төсөвт, 13,012.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 381,562.5 мянган төгрөг буюу 96.7 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 13,012.2 мянган төгрөгийг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Боловсрол шинжлэх ухааны газраас ариутгал халдваргүйтгэлийн зардалд 250.0 мянган төгрөг, тендер зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотой орлого 140.0 мянган төгрөгийг тус тус нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Үүнээс бичиг хэргийн зардалд 140.0 мянган төгрөг, ариутгал халдваргүйтгэлийн зардалд 250.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Бялзуухай цэцэрлэг нь 2021 онд нийт 450.622,5 мянган төгрөгийн 147 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй, 141 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж, худалдан авах үйл ажиллагаатай холбогдолтой 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн,

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар анхаарал татахаар бөгөөд бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 30.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээр, 30.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж, материаллаг бус алдаа зөрчилд 1 зөвлөмж хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Тайлант онд залруулсан алдаа гараагүй байна.

4.2 Албан шаардлага

Тайлант онд гарсан алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлээгүй болно.

4.2 Акт

Тайлант онд гарсан алдаа зөрчилд акт хүргүүлээгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Шилэн дансанд 11, 12-р сард худалдан авах ажиллагаатай холбоотой 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 мэдээллийн үнэн зөв, бодитой, иж бүрэн байх 4.1.3 “тогтоосон хугацаанд мэдээллэдэг байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлж, дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх, хариуцлагыг сайжруулах.

2. Авлага өглөгийн тайлагналтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант оны эцэст 30.8 мянган төгрөгийн НДШ-ийн авлагын үлдэгдэлтэй гарсан ба энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтын дагуу "төсвийг зохистой удирдаж өр авлага үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2. Зөвлөмж:

Тайлант хугацаанд төсвийг зүй зохистой удирдаж өглөг авлага үүсгэх байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн нэгтгэл		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орхон аймгийн Бялзуухай цэцэрлэг	2	30.8							2	30.8
Нийт		2	30.8							2	30.8

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:

“БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ” ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР:

Б.Пүрэвсүрэн

Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР, ЗАХИРАЛ :

Д.Мягмарсүрэн

Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Б.Эрдэнэ

Б.ЭРДЭНЭ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Ц.Нармандах

Ц.НАРМАНДАХ

